



ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 17 өдөр

Дугаар #128

Улаанбаатар хот

**Засвар үйлчилгээний хөлсийг
олгох тухай**

“Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн дүрэм”-ийн 3.9.1 дэх заалт, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн “Эм Жи Эм Ди” ХХК-тай 2019 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан “Засварын ажил гүйцэтгэх гэрээ”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус хүрээлэнгийн механик цех, нойтон цех, хуурай цехүүдийн халаалтын шугам хоолойнуудыг бүрэн шинэчлэн сольж сантехникийн их засвар хийлгэх “Эм Жи Ди Эм” ХХК-тай байгуулсан “Засварын ажил гүйцэтгэх гэрээ”-ний 1.6 дахь заалтын дагуу засвар үйлчилгээний хөлсийг олгосугай.
2. Засвар үйлчилгээний нийт төлбөр болох 6,300,000 /зургаан сая гурван зуун мянга/-н төгрөгийг урсгал засварын зардлаас /210604/ гаргахыг нягтлан бодогч /Т.Болормаа/-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ *Т.Поршова* Т.ТӨРМӨНХ



Батлав: ХҮСХХ-ийн захирал



Т.Төрмөнх

ХҮСХХ-н баруун байрны сантехникийн засварын төсөв

2019.09.17

№	Материалын тооцоо	х/н	тоо	үнэ	Бүгд үнэ
1	Ф50 ППР хоолой	м	50	9350	467500
2	Ф40	м	40	7150	286000
3	Ф32	м	72	5850	421200
4	Ф25	м	60	4750	285000
5	Ф20	м	48	3750	180000
6	Ф50 вентиль	ш	2	36000	72000
7	Ф32 вентиль	ш	2	25000	50000
8	Ф20 винтель	ш	28	15000	420000
9	Холбох хэрэгсэл	кг	20	45000	900000
10	Электрод	кг	5	2400	12000
11	Таслагчийн ир	ш	10	990	9900
12	Лен олс	ш	4	2000	8000
13	Лент	ш	5	3000	15000
14	Булан төмөр	м	72	4000	288000
15	Радиатор	секц	42	25000	1050000
16	Унаа	удаа	2	80000	160000
17	Будаг	кг	20	6270	125400
18	Техникийн сод	кг	10	5000	50000
19	Ажлын хөлс				1500000
дүн					6,300,000


Тооцоо гаргасан :

ХҮСХХ-ийн ААнярав



Н.Баттоогоо

ХҮСХХ-ийн нягтлан бодогч



Т.Болормаа





ХҮСХХүрээлэнгийн захирал.

/Т.Төрмөнх/



Эм. Жи. Эм. Ди. ХХК-ы захирал

/Б.Мөнхзул/

Засварын ажил гүйцэтгэх гэрээ

2019 оны 09 сарын 17 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас..... *ХҮСХХүрээлэн*/цаашид захиалагч гэх/ нөгөө талаас.....

Эм. Жи. Эм. Ди. ХХК/цаашид гүйцэтгэгч гэх/ бид Монгол улсын Иргэний хуулийн

343-358 дугаар зүйлийг удирдлага болгон дараахи гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг заалт

1.1. Энэхүү гэрээний зорилго нь тус ХҮСХХүрээлэнгийн механик цех, нойтон цех, хуурай цехүүдийн халаалтын шугам хоолойнуудыг бүрэн шинэчлэн сольж сантехникийн их засвар хийхэд оршино.

1.2. захиалагч нь засварын ажлын зураг төсөв болон ажиллах нөхцлөөр хангана.

1.3. Гүйцэтгэгч нь засварын ажлыг хугацаанд нь чанартай сайн хийж гүйцэтгээд захиалагчид хүлээлгэн өгнө.

1.4. 6300000 төгрөгний төсөвтэй засварын ажлыг 2019 оны 09 сарын 17-ээс гүйцэтгэж эхлээд 2019 оны 10 сарын 01 өдөр хүлээлгэн өгнө.

1.5. Хийж гүйцэтгэсэн ажилд гологдол, доголдол гарвал компани өөрийн хөрөнгөөр ... жилийн хугацаанд засаж өгнө.

1.6. Засварын ажлын санхүүжилтийг 2 хувааж санхүүжүүлнэ. Засварын ажил эхлэхийн өмнө нийт төсөвийн 70% болох 4410000 төгрөгийг, засварын ажил дууссны дараа 30% болох 1890000 төгрөгийг шилжүүлнэ.

1.7. Хэрэв шалтгаангүйгээр санхүүжүүлээгүй тохиолдолд өдрийн 0.1% -ийн алданги тооцож төлнө.

1.8. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ хароилцан тохиролцож буюу



Монгол улсын иргэний болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөгө болгоно.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

- 2.1. Захиалагч нь гүйцэтгэгчийн хийж засаж байгаа ажлын чанарт хяналт тавих эрхтэй.
- 2.2. Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажил үүргээ биелүүлээгүй болон зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд засаж хийлгэх, нөхөн хийхийг шаардлах эрхтэй.
- 2.3. Захиалагч нь засварын ажил шаардлага хангаагүй тохиолдолд ажлыг хүлээн авахгүй байх эрхтэй.
- 2.4. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг чанартай хийж гүйцэтгэсэн гэж үзвэл санжүүжилтыг саадгүй хугацаанд нь шилжүүлэх үүрэгтэй.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх үүрэг.

- 3.1. Гүйцэтгэгч засварын ажлыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх үүрэгтэй.
- 3.2. Засварын ажилтай холбоотой тодруулга захиалагчаас шаардах эрхтэй.
- 3.3. захиалагч гүйцэтгэсэн ажлыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн авахгүй бол ажлыг гүйцэтгэсэнд тооцож ажлын хөлсийг нэхэмжлэх эрхтэй.
- 3.4. Өөрсдөөс шалтгаалсан ажлын үр дүнгийн гологдлыг арилгахад шаардагдах зардлыг хариуцана.
- 3.5. Гүйцэтгэсэн ажилдаа нэг жилийн баталгаа өгнө.

Захиалагчийг төлөөлж:

Нярав......../Н.Баттоогоо/

Гүйцэтгэгчийг төлөөлж:

инженер......../А.Баяраа/

Засварчин......../Р.Пүрэвдорж/